

ЯПОН ОРОН, ЯПОНЧУУД

Тоон хэлээр товч өгүүлсү:

НУТАГ

Японы нутаг нь умраас өмнөдөд 3800 километрт цуварсан урт, нарийн арлуудаас бүтэх бөгөөд Хоккайдо, Хоншю, Шикокү, Кошү гэсэн дөрвөн арал. бусад 6,848 жижиг арлаас бүрдэнэ. Нутгийн хэмжээ 377,800 км² бөгөөд 47 перфектурт хуваагдана. Нутгийн 75 хувь нь уул бусад нь газар тариалан, хот тосгонд ашиглагдах тал нутаг ажээ. Японы нутагт дэлхийн идэвхтэй галт уулсын 10-ны нэг нь байдаг.

ХҮН АМ

Хүн ам 125 сая бөгөөд дэлхийд 7 дугаар байр эзэлнэ. Хүн амын есөлт 1 хувиас доош орсон бөгөөд одоо 0,21 хувь байна. Нэг км² нутагт 332 хүн амьдарна. Нэг саяас дээш хүн амтай 11 хоттой, нийслэл Токиод 8 сая хүн суудаг. Гадаадад Японы 687 мянган иргэн амьдарна. Японд гадаадын 1,281 мянган иргэн амьдрал сууж байна. Япончууд дэлхийд хамгийн урт насалдаг (эрэгтэй нь 76,3, эмэгтэй нь 82,5). Хүн амын 14 хувь нь 60-аас дээш настай.

ЗАСГИЙН ГАЗАР

Гүйцэтгэх засаг нь 13 яамдаас бүрдэнэ. Төрийн сайд тэргүүтэй 9 агентлаг (батлан хамгаалах, эдийн засгийн төлөвлөлт, шинжлэх ухаан, технологи, байгаль орчин гэх мэт) ажиллана. Гадаадад элчин сайдын 112 яам, ерөнхий консулын 71 газар, олон улсын байгууллага дахь 6 төлөөлөгчийн газартай.

Дайт (парламент) нь 511 гишүүнтэй, 300 гишүүд нь мажиртор, 211 нь пропорционал системээр 4 жилийн хугацаагаар сонгогдоно. Танхимыг ерөнхий сайд хугацаанаас нь өмнө тарааж болно.

Дайт дахь улс төрийн намуудын байдал гэвэл: 1955 оноос Либерал ардчилсан нам (ЛАН) засгийн эрхэнд, социал демократ нам (СДН) сөрөг хүчин байсан. 1993 оноос ЛАН-д хагарал гарч ноёрхох байдлаа алдсан. 1995 оны 3 дугаар сараас ЛАН СДН, Сакигаке гэдэг шинэ намуудаас бүрдсэн эвслийн засгийн газрыг ерөнхий сайд Томичи Мураяама толгойлж байв. Эдүгээ тус улсын Засгийн газрын тэргүүнээр Р. Хашимото ажиллаж байна.

ДИПЛОМАТ АЛБА

Японы гадаад бодлогын тулгын чулуу нь АНУ-тай дотно, хамтын хамтын ажиллагааны харилцаатай байх явдал бөгөөд аюулгүй байдлын үндэс суур нь 1960 онд байгуулсан Япон—Америкийн аюулгүйн гэрээ мөн. Хятад ба Өмнөд Солонгостой тогтвортой харилцаатай байх, ингэснээр Ази, Номхон далайн бүхэл бүс нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулах явдал юм.

НҮБ-ын санхүүжилтийн ихэнх болох 25 хувийг АНУ, 12.5 хувийг Япон гаргадаг. Хөгжлийн тусламж үзүүлдэг орнууд (ДАК)

1993 онд хөгжиж буй орнуудад 54,7 тэрбум ам.долларын тусламж үзүүлсэн байхад 11,3 тэрбум буюу 20,5-ыг Япон, 9 тэрбум буюу 16,5 хувийг АНУ гаргажээ.

БАТЛАН ХАМГААЛАХ

Дайн хийх, хүч хэрэглэхээр заналхийлэх замаар олон улсын маргааныг шийдвэрлэхийг Японы үндсэн хуулиар хориглосон. Японы өөрийгөө хамгаалах хүчний зэвсэглэлд тив алгасан нисэх пуужин, алсын бөмбөгдөгч онгоц байхгүй. Японы засгийн газар батлан хамгаалах зардлаа нийгмийн нийт бүтээгдэхүүний 1 хувиас хэтрүүлэхгүй гэж тогтсон нь том гүрнүүдийнхээс маш доогуур хэмжээ юм. Япон батлан хамгаалах зардалд 17 тэрбум ам.доллар зарцуулж буй нь хүн ам тутамд 136 ам. доллар оногдож байна. Зардлын нийт хэмжээгээр Япон дэлхийн том 6 улсын дараа, нэг хүнд оногдохоор 5 улсын дараа орж байна. Нийгмийн нийт бүтээгдэхүүн (ННБ)-д баглан хамгаалахын зардал АНУ-д 5,3, Орос 9,9, Хятадад 5 хувь байна.

ЭДИЙН ЗАСАГ

Японы эдийн засгийн өсөлт 1960—1970 онд жилдээ 10 хувиас дээш байсан бол сүүлийн жилүүдэд буурч ирсэн бөгөөд 1993 оны өсөлт 0,1 хувь, 1994 оных 0,6 хувь болон сэргэж байна. 1994 оны байдлаар Японы ННБ 469 триллион иен болсон нь АНУ-ын 68,3 хувьд хүрчээ. Хүн ам тутамд оногдох ННБ 1993 онд Японд 33,903 ам.доллар болсон бол АНУ 25,009, Хятад 458. Орос 387 доллар байна. Өргөн хэрэгцээний барааны үнэд холбогдох инфляцийн түвшин сүүлийн 5 жилд 1,6—3,3 хувь байна.

АМРАЛТ, СПОРТ

Амралт. Аж байдал сайжирсан, 5 өдрийн ажлын 7 хоног нэвтэрч буйгаас Япончууд амралт, зугаалгад анхаарах нь өсөж байна. Жилд Японы 10 сая хүн гадаадад жуулчилж, гадаадын 1,7 сая жуулчин Японд ирж байна. Япончууд жилд 3 удаа дотоодын жуулчлалд өргөн оролцоно. Энэ нь шинэ жилээр болдог өвлийн амралт, 4—5 сард болдог «алтан долоо хоног», 7—8 сард болдог зуны амралт болно.

Спорт. Япончууд сагсан бөмбөг, сумо барилдаан, хөл бөмбөг их сонирхоно. 1600 оноос хөгжсөн сумо барилдааны тэмцээн жилд 6 удаа болдог.

АЖ ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙ

Япончуудын хоол хүнсний гол зүйл болох цагаан будааны үйлдвэрлэл нь хэрэглээнээс давсан, хүнсний ногоо, жимсээр өөрийгөө хангадаг, харин улаан буудайны 12 хувь, махны 65 хувийг өөртөө үйлдвэрлэж бусдыг импортлоно. Японы нутгийн 3-ны 2-ыг ой мод эзэлдэг боловч мод материалын хэрэгцээний 20—30 хувийг өөртөө үйлдвэрлэдэг. Эрдэс түүхий эд болох төмрийн хүдэр, зэс, никел, боксит зэргийг бараг 100 хувь импортлодог. 1990 оны байдлаар загас агналтаар Хятад 13,8 сая тонн, Япон 11,1, Орос 10,5 тоннд хүрч дэлхийд тэргүүн байр эзэлжээ. 1992 оны байдлаар ган хайлалтаар Орос 140

сая тонн, Япон 98 сая тоннд хүрч дэлхийд тэргүүн байр эзэлсэн байна. Суудлын автомашин, үйлдвэрлэлтээр Япон 1 байр буюу 9,9 сая, АНУ II байр буюу 6,1 сая байжээ.

ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

1983 онсоос хойш Японы худалдааны ашиг маш өндөр байв. 1985 онд 240 иен л доллартай тэнцэж байснаа жил ирэх тутам үнэ нь өсөж одоо 100 иен 1 ам.доллартай тэнцэх болов. 1993 оны байдлаар Японы экспорт 362 тэрбум буюу дэлхийн 9 хувь, импорт нь 241 тэрбум буюу дэлхийн 6,2 хувь болж АНУ, Германы дараа дэлхийд III байр эзэлж байна. 1992 оны байдлаар АНУ-ын шууд хөрөнгө оруулалт 668 тэрбум, Английнх 285 тэрбум, Японых 248 тэрбум болж дэлхийн тэргүүн байруудыг эзлэв.

АЖИЛЛАХ ХҮЧИН

Ажилгүйдэл Канад, Францад 11 гаруй, Англи, Италид 10 гаруй, Германд 8,2, АНУ-д 6,8 хувь байхад Японд 2,5 хувь байна. Японы цалингийн тогтолцоо тухэн уламжлалаар удаан жил ажилласнаар үндэслэгдэж ирсэн бол одоо үед хүмүүсийн албан тушаал чадварыг голлох болж байна. 1993 оны мэдээгээр өргөн хэрэгцээний барааны үнэ урьдах оноос 1,3 хувь өссөн байхад цалин 0,7 хувь, бодит цалин 0,6 хувь өсчээ. Одоо үед Японы ажлын цаг 7 хоногт 39,3 (АНУ-д 42,6, Германд 39,5, Францад 38,7) байна.

ЭРЧИМ ХҮЧ

Эрчим хүчний хэрэглээ жил тутам өсөж байна. Эх булгийн хувьд нефть 1973 онд 77,4 хувь байсан бол 1993 онд 56,6 хувь болж цөмийн эрчим хүч 11,1, шатдаг хий 10,7 хувь болж өсөв. Япон жилдээ 256 сая тонн түүхий нефть импортлож буйн 23 хувийг Индонез, Хятадаас, бусдыг Ойрхи Дорнодоос, гол нь Саудын Арабаас авч байна.

ТЭЭВЭР

Төмөр замын өтгөн сүлжээ Японыг хэрдэг. Сүүлийн жилд автомашины тээвэр их хөгжив. Хотуудын хооронд автобус явах нь ихсэж, илгээлтийг гэрт нь хүргэх үйлчилгээ өсөж байна. Япон төмөр зам 1872 оноос эхэлсэн. 1964 оноос Шинкансен (Суман галт тэрэг) явах болсон. Үүний хамгийн хурд нь цагт 270 км гүйдэг. Японы 4 том хот метротой, бүх шугам нь 453 км. Автомашины засмал зам 249 мянган км. Одоо Японд 64,5 сая автомашин хөдлөж байна. 18 нас хүрэгсэд автомашин, 16 настай мотоцикл жолоодох эрхтэй. Насанд хүрсэн эрэгтэйчүүдийн 80,2, эмэгтэйчүүдийн 47,4 хувь нь жолоочийн үнэмлэхтэй. 1972 оны мэдээгээр зам тээврийн ослоос АНУ-д 39235 хүн, Японд 13269 хүн нас барсан нь 100000 хүн тутамд 15,4, 10,6 оногдож байна.

Япон нь агаарын 3 шугамтай. Нисэх буудлуудыг засаж шинэтгэх ажил өрнөж буй. 1994 оны 24 цагаар ажилладаг Кансай гэдэг олон улсын буудал Осака хотын дэргэд нээгдсэн. Олон улсын нислэгээр зорчигчид 36 саяд хүрчээ.

ХОЛБОО ХАРИЛЦАА

Дотоодын телеграф ба телефон холбоо улсынх байснаа 1985 оноос хувьчилсан. Одоо I зэргийн үйлчилгээтэй 86, II зэргийн 1589 компани утасгүй телефон, факсын холбоо өргөн нэвтрэв. Японд одоо 1000 хүн тутамд 21 телефон (Данид 972, Германд 671) ашиглагдаж байна.

Хувийн хадгаламж. Япончууд гэр орондоо үнэт хогшил багатай, сууцны үнэ өндрөөс голчлон шалтгаалж иргэдийн банкин дахь хадгаламж дэлхийн аль ч орноос их байдаг бөгөөд цалингийн 14 хувьтай тэнцэж байна. (Германд 12, Англи 8)

Удаан эдэлгээтэй эд хогшил гэвэл: Өнгөт телевиз өрхийн 99,1, стерео хөгжим 61,3, видео приставка 75,1, суудлын автомашин 80,0, хөргүүр шүүгээ 98,0, гагаар сэрүүцүүлэгч 72,3 микро долгионы зуух 81,3, пианин хөгжим 23,2 хувь байна.

Хоол хүнс. Жилдээ хүн тутмын идэж буй хоол хүнсний бүтцийг үзэхэд үр тариа 103 кг, ногоо 125, мах 41, загас ба далайн амьтац 66, сүүн бүтээгдэхүүн 84 кг байна.

Архи тамхи. Япончууд ногоон цай уух нь багасч, кофе уух нь ихсэж байна. Одоо үед нэг хүн жилдээ дунджаар 2,4 кг кофе ууж байна. (Герман 7,8, Франц 5,8) Жилдээ нэг хүн 6,3 литр архи (АНУ 7, Франц 11,9) хэрэглэж байна. Хүн амын 36,2 хувь тамхи татаж байгаа бөгөөд, эрэгтэйчүүдийн тоо буурч байхад эмэгтэйчүүдийнх 15 хувь болон өсөж байна.

Нийгмийн хангамж. Нийгмийн хангамжид улсын орлогын 15 хувь буюу 53,8 трилион мөн зарцуулж буйн 27,6 нь тэтгэвэрт, 20,8 нь эрүүл мэндэд, 5,4 нь бусад зүйлд зориулагдаж байна. 1994 оноос тэтгэврийн нас 60 байсныг 65 болгожээ. 1993 оны байдлаар Японы нэг хүн өндөр насны тэтгэвэрт сардаа 156000 иен авч буй нь сарын 41,9 хувьтай тэнцэж байна. (Шведэд 191000 буюу 57,4 хувь байгаа) Японд 588 хүнд нэг их эмч, 74 хүнд эмнэлгийн нэг ор оногдож байна.

Орон сууц. Том хотуудад орон сууцны үнэ өндөр Учир хүмүүс төвөөс зайдуу газар суудаг учир ажилд очиход нь 40—80 минут зарцуулагдаж байна. Засгийн газар том хотуудын сууцны үнийг хүмүүсийн 5 жилийн орлогод хүртэл бууруулах зорилт тавьж байна. Хүн амын 62 хувь өөрийн хувийн байшинд, 38 хувь нь хөлсний байшинд сууж байна.

Хууль зүй, гэмт хэрэг. Токио хот дэлхийн том нийслэлүүдийн хамгийн аюулгүйд тооцогддог. Гол шалтгаан нь галт зэвсэг, сэлэм эзэмшихийг хатуу хорьдогтой холбоотой. 1993 оны мэдээгээр Японд 100000 хүн тутамд оногдох гэмт хэрэг 1,444 байна. Мөн онд 1.198.699 хүн шийтгэгдсэний 7 нь алах ял, 27 нь насаараа хоригдох, 1.142.241 нь торгууль төлөх ял шийтгэгджээ. Японы цагдаагийн газарт 259,098 хүн ажиллаж буйн 5.800 нь эмэгтэйчүүд байна. Хүн амд оногдох цагдаагийн тоогоор Япон бусад том орнуудыг тэргүүлдэг. Хэрэг гарсан газарт дунджаар 5 минут 47 секундэд хүрэлцэн очиж чаддаг учир хэрэг илрүүлэлт сайн байдаг. Мансууруулах бодит оруулах, эзэмших, хэрэглэхийг хатуу хориглодог.

ШИНЖЛЭХ УХААН

Шинжлэх ухааны ба технологийн эрдэм шинжилгээний ажлын хөрөнгө оруулалтыг хувийн хэвшил ихэвчлэн хийдэг. Улсын төсвөөс 1994 онд энэ зорилгоор зарцуулсан хөрөнгө төс-

вийн 3,2 хувийг эзэлж байна. 1992 оны байдлаар Японы технологийн экспорт, түүний импортын 61 хувьтай тэнцэж байжээ. Патентынхаа 49 хувийг АНУ-д худалдаж, 31 хувийг АНУ-аас авч байна.

БОЛОВСРОЛ

Японд 6 жилийн бага, 3 жилийн дунд боловсролыг улсын зардлаар олгоно. Цэцэрлэгт 3—6 насандаа, бага дунд ангид 6—15, ахлах ангид 15—18, техникийн коллежид 15—20, коллежид 18—20, их сургуульд 18—22 насандаа суралцана. Японд нэг багшид бага сургуульд 21, дунд сургуульд 17 сурагч, дээд сургуульд 19 оюутан оногддог.

Японд гадаадын 52 мянган оюутан суралцаж буй нь АНУ, Францтай харьцуулахад маш цөөн байна. Эдгээрийн 87 хувь нь хувийн зардлаар суралцдаг, 91 хувь нь Азийн орнуудынх юм. Японы 136162 иргэн гадаадад сурдагийн 57 хувь нь АНУ-д ажээ. 1993 оны байдлаар гадаадын 77000 хүн Японд япон хэл сурч байна. Гадаад орнудад (голчилон Азийн орнуудад) япон хэл суралцагчдын тоо 1,6 саяд хүрээд байна.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ

Үндэсний хэмжээгээр уншигддаг 6 том сонин ба орон нутгийн үй олон сонинтой. Сонинууд худалдаанаас 45,5 зарлалаас 40,8 хувийн орлого олдог. Иомиури 9,7, Асахи 8,2, Маиничи 4 сая хувь хэвлэгддэгээрээ дэлхийд тэргүүлдэг. Японд өдөр тутамд 125 сонин 72,5 сая хувиар хэвлэгддэг нь 1000 хүн тутамд 587 сонин оногдож байна. Үүгээрээ Япон дэлхийд тэргүүлдэг. Японы радио, телевиз нь Эн Эйч Кей (Япон нэвтрүүлгийн корпораци) ба арилжааны станцууд, хиймэл дагуулын болон кабелийн станцуудаар явагдана. Радио нэвтрүүлгийн хөтөлбөрийн 3,8 хувь боловсролд, 15,6 хувь соёлд, телевизийн 12,9 хувь боловсролд, 24,5 хувь нь соёлд зориулагдаж байна. Японд гадаадын хэвлэлийн 315 төлөөлөгчийн газарт 766 сурвалжлагч ажиллаж байгаа бол Японы 641 сурвалжлагч гадаадад ажилладаг.

СОЁЛ

Хэвлэлийн үнийн өсөлтөөс болоод хямд үнэтэй сэтгүүлийн худалдаа илүүтэй өсөж байна. Японд 2491 сэтгүүл хэвлэгдэж байна. 1994 онд 48824 шинэ ном хэвлэгджээ. Японы 1953 номын санд 166 сая ном байна.

Кино. Телевиз, видео их хөгжсөн учир кинотеатрт очих хүн 1960 онд жилдээ 1 тэрбум байснаа 1994 онд 122 сая болтлоо буурчээ.

Хөгжим. 1982 онд компакт диск гарснаас болоод пьнз, кассет үйлдвэрлэгдэх нь цөөрлөө. Одоо үед Японы өрхийн талас илүү хувь нь компакт диск тоглуулагчтай болжээ. 1993 оны байдлаар 342 мянган пьнз хийгдсэн нь 0,2 хувь, 381 сая компакт диск хийгдсэн нь 91,3 хувь, 35 сая кассет хийгдсэн нь 8,5 хувийг эзэлж байна.

НААХУ ХЭВЛЭЛ